**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 13 өдөр Дугаар 39 Номгон

Зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Аймгийн "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл"-ийн гишүүн Д.Жаргалсайхан, Ч.Баяр нарыг зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, зөвлөлийн гишүүнээр Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Т.Гансболд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга Я.Сайнжаргал нарыг оруулан шинэчлэн баталсугай.

ДАРГА Д.ШИРМЭН

D:My Document\ togtool
0114453

1211

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 13 өдөр Дугаар 40 Номгон

Монгол Улсын "Гавьяат" цол,
төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах хүмүүсийн
тодорхойлолт өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН "ГАВЪЯАТ БАГШ" ЦОЛООР

1. Гончигийн Батнасан Өлзийт сум ахмад настан

"ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ГООР

2. Гянхарын Цогнамжил Баянлиг сум ахмад настан
3. Авирмэдийн Бурмаа Баянлиг сум Татварын улсын байцаагч

"ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОН"-ГООР

4. Довчингийн Мөнхбаатар Шүүхийн шинжилгээний албаны дарга

"АЛТАН ГАДАС ОДОН"-ГООР

5. Доржийн Чонцолдулам Баянлиг сум Бага ангийн багш
6. Буяндэлгэрийн Бархассүрэн Баянлиг сум Засаг даргын орлогч
7. Сэрээхүүгийн Лхамдинмаа Өлзийт сум Хими-биологийн багш
8. Пүрэвийн Батчулуун Баянлиг сум "Дэлгэрэх баян уул" хоршооны дарга

D:My Document\ togtool

0114463

9. Норовын Батсайхан — "ЦДҮС" ТӨХК-ийн монтёр
10. Дашзэвэгийн Жаргалсайхан — "ЦДҮС" ТӨХК-ийн зэлжийн техник

"ШУДАРГА ЖУРАМ МЕДАЛЬ"-ИАР

11. Дарьсүрэнгийн Чулуунбаатар — Баян-Өндөр сум 2 дугаар багийн малчин
12. Чойжоогийн Бэгзжав — Баян-Өндөр сум 2 дугаар багийн малчин

"ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ИАР

13. Дашвандангийн Цэрэн — Өлзийт сум Монгол хэлний багш
14. Дагвын Оюун — Өлзийт сум Бага ангийн багш
15. Цагааны Жаргал — Өлзийт сум Англи хэлний багш
16. Жамбын Цэрэндэгд — Өлзийт сум Бага ангийн багш
17. Цэрэнпилийн Тэгшбаяр — Өлзийт сум Дотуур байрны багш
18. Рэнцэнгийн Нармандах — Эрдэнэцогт сум 2 дугаар багийн малчин
19. Бямбаагийн Ган-Очир — Эрдэнэцогт сум 4 дүгээр багийн малчин
20. Пунцагийн Сангитамжид — Эрдэнэцогт сум 4 дүгээр багийн малчин
21. Гончигийн Батпалам — "Их Богдын зам" ХХК-ний инженер
22. Цэвэлийн Чулуунбат — Богд сум 2 дугаар багийн малчин
23. Бямбаагийн Норовхүү — Богд сум 2 дугаар багийн малчин
24. Дуламын Банзрагч — Богд сум 2 дугаар багийн малчин
25. Доржийн Баттогоо — Богд сум Төслийн ажилтан
26. Адъяагийн Баатар — Богд сум сургуулийн манаач
27. Цэрэндондовын Жигжидсүрэн — Баянлиг сум Бага ангийн багш
28. Сангийн Бямбахорол — Баянлиг сум ахмад багш
29. Пийтэрийн Энхтуяа — Баянлиг сум Насан туршийн боловсролын менежер
30. Дондогийн Оюунчимэг — Баянлиг сум Газар зүйн багш
31. Нацагдоржийн Дэлгэр — Баянлиг сум Соёлын төвийн үйлчлэгч
32. Бадамхоролын Энхбат — Баянлиг сум 1 дүгээр багийн малчин
33. Авирмэдийн Мөнхтөр — Баянлиг сум 5 дугаар багийн малчин
34. Шарбандийн Адъяа — Баянлиг сум 4 дүгээр багийн малчин
35. Дуламын Эрдэнэчимэг — Баянлиг сум 4 дүгээр багийн малчин
36. Жанчивдоржийн Жаргалсайхан — "ЦДҮС" ТӨХК-ийн инженер
37. Цэрэндагвын Эрдэнэбямба — Баянлиг сум ЗДТГазрын жолооч
38. Дуламын Ширэндэв — Баянлиг сум ахмад настан

| | |
|---|---|
| 39. Цогвоогийн Хайшин | Баянлиг сум ахмад настан |
| 40. Гэндэнсономын Найдансурэн | Баянлиг сум ахмад настан |
| 41. Дэчингийн Рэнцэндорж | Баянлиг сум ахмад настан |
| 42. Маамын Цэдвээ | Баянлиг сум ахмад настан |
| 43. Доржсүрэнгийн Хүүхнээ | Баянлиг сум ахмад настан |
| 44. Самбуугийн Янжинхорол | Баянлиг сум ахмад настан |
| 45. Дагдангийн Лундэн | Баянлиг сум ахмад настан |
| 46. Гончигдоржийн Данзан | Баянлиг сум ахмад настан |
| 47. Бадарчийн Нэргүй | Баянлиг сум ахмад настан |
| 48. Цэрэнцоогийн Төмөрбат | Баянлиг сум ахмад настан |
| 49. Нямдоржийн Лхагва | Баянлиг сум ахмад настан |
| 50. Онхоодойн Отгон | Баянлиг сум ахмад настан |

ДАРГА Д.ШИРМЭН

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 13 өдөр　　　Дугаар 41　　　Номгон

Орон нутгийн өмчөөс төрийн өмчид
хөрөнгө шилжүүлэх тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоол, Зам тээврийн сайдын 2015 оны 65 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг Тээвэр, авто замын газрыг Авто тээврийн үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбартай нэгтгэж байгаа тул эргэлтийн хөрөнгө, өр авлагыг нэгдүгээр хавсралтаар орон нутгийн өмчөөс төрийн өмчид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА　　　　　　Д. ШИРМЭН

D;2015on/ITHT_Togtool/2015
0112469

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
41 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖСЭН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ, АВЛАГА, ӨГЛӨГИЙН ЖАГСААЛТ

| № | Үндсэн хөрөнгийн нэр | Акхны үнэ | ДҮН |
|---|---|---|---|
| 1 | Хангамжийн материал | Бичиг хэргийн материал | 967590 |
| | | Аж ахуйн материал | 870000 |
| | | Сэлбэг хэрэгсэл | 2983000 |
| | | Бусад хангамжийн материал | 1458540 |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | | 6279530 |
| 2 | Бусад авлага | НДШ-ийн тооцоо | 2104235.00 |
| | | Дээд байгууллагаас авах авлага | 919400.00 |
| | Авлагын дүн | | 3023635.00 |
| 3 | Өглөг | Пратакал даатгал | 919400.00 |
| | Төрийн өмчид шилжих хөрөнгийн дүн | | 10222565.00 |

oOo

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 13 өдөр Дугаар 42 Номгон

Хөренгө шилжүүлэх, актлах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 3 дах заалт, Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоол, Зам тээврийн сайдын 2015 оны 65 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2015 оны 173 дугаар захирамж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам"- ын холбогдох заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг Тээвэр, авто замын газрыг Авто тээврийн үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбартай нэгтгэж байгаа тул үндсэн хөрөнгийг Орон нутгийн өмчийн албанд нэгдүгээр хавсралтаар, Замын байцаагчийн ашиглаж байсан хөрөнгүүдийг хоёрдугаар хавсралтаар аймгийн Засаг даргын Тамгын газарт тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Нэг, хоёрдугаар хавсралтад заагдсан хөрөнгүүдийг орлогоор хүлээн зөвшөөрч үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

3. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг Тээвэр, авто замын газарт ашиглагдаж байсан цаашид ашиглах боломжгүй болсон 8 нэрийн 1629188,27 төгрөгийн хөрөнгийг гуравдугаар хавсралт ёсоор актлаж данснаас хассугай.

4. Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгах нь:

4.1. Орон нутгийн өмчит Тээвэр, авто замын газрын хөрөнгийг хүлээлцэх комисс томилсугай.

4.2. Авто тээврийн үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарт шилжин ажиллаж байгаа ажилчдын ашиглаж байгаа хөрөнгүүдийг актаар хүлээлгэн өгч салбарын даргатай ашиглалтын гэрээ байгуулсугай.

4.3. Акталсан хөрөнгүүдийг жагсаалтаар хүлээн авч устгал хийсүгэй.

4.4. Татан буугдсан Тээвэр авто замын газрыг Орон нутгийн өмчит байгууллагын жагсаалтаас хассугай.

4.5. Шилжүүлсэн, акталсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажилласугай.

ДАРГА Д. ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
42 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралт

## ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБАНД ШИЛЖҮҮЛСЭН ТАВИЛГА ЭД ХОГШЛИЙН БҮРТГЭЛ

| № | № | Хөрөнгийн нэр | Ашиглах жил | А.О.Огноо | Нэгжийн үнэ | Эхний | Тоо | Эцсийн | Хур элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлах байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тээвэр авто замын газар | Дэлгэц компьютерийн | 4.0 | 2013/09/25 | 286,000.00 | 286,000.00 | 1.0 | 286,000.00 | 89,374.95 | 196,625.05 | Орон нутгийн өмчийн алба |
| 2 | Тээвэр авто замын газар | Комьютерийн ширээ | 10.0 | 2007/06/13 | 80,000.00 | 80,000.00 | 1.0 | 80,000.00 | 60,666.83 | 19,333.17 | Орон нутгийн өмчийн алба |
| 3 | Тээвэр авто замын газар | Мөнгөний сейф | 10.0 | 2008/12/15 | 98,000.00 | 98,000.00 | 1.0 | 98,000.00 | 59,616.83 | 38,383.17 | Орон нутгийн өмчийн алба |
| 4 | Тээвэр авто замын газар | Бичгийн ширээ | 10.0 | 2009/11/01 | 188,000.00 | 376,000.00 | 2.0 | 376,000.00 | 194,267.00 | 181,733.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 5 | Тээвэр авто замын газар | Хувцасны өлгүүр | 10.0 | 2009/12/01 | 38,000.00 | 38,000.00 | 1.0 | 38,000.00 | 19,316.83 | 18,683.17 | Орон нутгийн өмчийн алба |
| 6 | Тээвэр авто замын газар | Саарал сейф | 10.0 | 2009/12/01 | 260,000.00 | 260,000.00 | 1.0 | 260,000.00 | 132,266.82 | 127,733.18 | Орон нутгийн өмчийн алба |
| 7 | Тээвэр авто замын газар | Хуйлдаг хөшиг | 10.0 | 2009/11/01 | 49,000.00 | 98,000.00 | 2.0 | 98,000.00 | 50,633.49 | 47,366.51 | Орон нутгийн өмчийн алба |
| 8 | Тээвэр авто замын газар | Асар майхан | 10.0 | 2010/06/28 | 600,000.00 | 600,000.00 | 1.0 | 600,000.00 | 275,000.00 | 325,000.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 9 | Тээвэр авто замын газар | Хивс | 10.0 | 2010/12/22 | 280,000.00 | 280,000.00 | 1.0 | 280,000.00 | 114,332.84 | 165,667.16 | Орон нутгийн өмчийн алба |
| 10 | Тээвэр авто замын газар | Тэнь | 10.0 | 2010/12/29 | 60,000.00 | 60,000.00 | 1.0 | 60,000.00 | 24,500.00 | 35,500.00 | Орон нутгийн өмчийн алба |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Тээвэр авто замын газар | Хивс жижиг | 10.0 | 2010/12/29 | 135,000.00 | 135,000.00 | 1.0 | 135,000.00 | 55,125.00 | 79,875.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 12 | Тээвэр авто замын газар | Гишг??р | 10.0 | 2010/12/29 | 45,000.00 | 45,000.00 | 1.0 | 45,000.00 | 18,375.00 | 26,625.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 13 | Тээвэр авто замын газар | Note book компьютер | 4.0 | 2011/09/01 | 1,000,000.0 | 1,000,000.00 | 1 | 1,000,000.00 | 833,333.20 | 166,666.80 | Орон нутгийн өмчийн алба |
| 14 | Тээвэр авто замын газар | Факсын аппарад | 10.0 | 2011/12/22 | 250,000.00 | 250,000.00 | 1.0 | 250,000.00 | 77,083.21 | 172,916.79 | Орон нутгийн өмчийн алба |
| 15 | Тээвэр авто замын газар | Кассын Принтер | 4.0 | 2011/12/22 | 480,000.00 | 480,000.00 | 1.0 | 480,000.00 | 370,000.00 | 110,000.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 16 | Тээвэр авто замын газар | Толь | 10.0 | 2011/12/22 | 35,000.00 | 35,000.00 | 1.0 | 35,000.00 | 10,791.79 | 24,208.21 | Орон нутгийн өмчийн алба |
| 17 | Тээвэр авто замын газар | Ширээ / шар / | 10.0 | 2012/10/02 | 356,000.00 | 356,000.00 | 1.0 | 356,000.00 | 80,100.09 | 275,899.91 | Орон нутгийн өмчийн алба |
| 18 | Тээвэр авто замын газар | Сейф хар саарал | 10.0 | 2012/10/02 | 348,000.00 | 348,000.00 | 1.0 | 348,000.00 | 78,300.00 | 269,700.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 19 | Тээвэр авто замын газар | Сандал / дарга | 10.0 | 2012/11/14 | 200,000.00 | 200,000.00 | 1.0 | 200,000.00 | 43,333.42 | 156,666.58 | Орон нутгийн өмчийн алба |
| 20 | Тээвэр авто замын газар | Сандал 96.0 | 10.0 | 2012/11/14 | 96,000.00 | 384,000.00 | 4.0 | 384,000.00 | 83,200.00 | 300,800.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 21 | Тээвэр авто замын газар | Сейф ШБТовчоо | 10.0 | 2012/11/14 | 240,000.00 | 240,000.00 | 1.0 | 240,000.00 | 52,000.00 | 188,000.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 22 | Тээвэр авто замын газар | 43 инчийн Телевизор Samsung | 10.0 | 2012/12/25 | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1.0 | 1,000,000.00 | 208,333.25 | 791,666.75 | Орон нутгийн өмчийн алба |
| | | | | | 6,124,000.00 | 6,649,000.00 | 27.00 | 6,649,000.00 | 2,929,950.55 | 3,719,049.45 | |

oOo

## ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБАНД ШИЛЖҮҮЛСЭН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БҮРТГЭЛ

Үргэлжлэл №2

| № | № | Хөрөнгийн нэр | Ашиглах жил | А.О.Огноо | Нэгжийн үнэ | Эхний | Тоо | Эцсийн | Хур элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Тээвэр авто замын газар | Барилга | 40.0 | 2008/12/01 | 4,591,192.00 | 4,591,192.00 | 1.0 | 4,591,192.00 | 666,291.89 | 3,924,900.11 | Орон нутгийн өмчийн алба |
| 24 | Тээвэр авто замын газар | Хаалт | 10.0 | 2009/11/01 | 1,031,180.00 | 1,031,180.00 | 1.0 | 1,031,180.00 | 532,776.49 | 498,403.51 | Орон нутгийн өмчийн алба |
| | | | | | | 5,622,372.00 | 2.00 | 5,622,372.00 | 1,199,068.38 | 4,423,303.62 | |

## НОМЫН ФОНДЫН БҮРТГЭЛ

| № | № | Хөрөнгийн нэр | Ашиглах жил | А.О.Огноо | Нэгжийн үнэ | Эхний | Тоо | Эцсийн | Хур элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | Тээвэр авто замын газар | Стандарт гарын авлага | - | 2013/10/25 | 50,000.00 | 50,000.00 | 1.0 | 50,000.00 | - | 50,000.00 | Орон нутгийн өмчийн алба |
| | | | | | | 50,000.00 | 1.00 | 50,000.00 | - | 50,000.00 | |

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

| № | № | Хөрөнгийн нэр | Ашиглах жил | А.О.Огноо | Нэгжийн үнэ | Эхний | Тоо | Эцсийн | Хур элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | Тээвэр авто замын газар | Машин дунд гарын жип | 8.0 | 2011/12/25 | 13,000,000.00 | 13,000,000.00 | 1.00 | 13,000,000.00 | 5,010,416.79 | 7,989,583.21 | Орон нутгийн өмчийн алба |
| | | | | | | 13,000,000.00 | 1.00 | 13,000,000.00 | 5,010,416.79 | 7,989,583.21 | |

oOo

## ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБАНД ШИЛЖҮҮЛСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛ

Үргэлжлэл №3

| № | № | Хөрөнгийн нэр | Ашиглах жил | А.О.Огноо | Нэгжийн үнэ | Эхний | Тоо | Эцсийн | Хур элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | Тээвэр авто замын газар | Компьютер | 4.0 | 2009/12/01 | 500,000.00 | 500,000.00 | 1.00 | 500,000.00 | 500,000.00 | - | Орон нутгийн өмчийн алба |
| 28 | Тээвэр авто замын газар | Цахилгаан зийн | 4.0 | 2008/09/01 | 65,000.00 | 65,000.00 | 1.00 | 65,000.00 | 65,000.00 | - | Орон нутгийн өмчийн алба |
| 29 | Тээвэр авто замын газар | Компьютер Делл | 4.0 | 2009/12/01 | 899,000.00 | 899,000.00 | 1.00 | 099,000.00 | 899,000.00 | - | Орон нутгийн өмчийн алба |
| 30 | Тээвэр авто замын газар | 3 үйлдэлт принтер | 4.0 | 2010/05/20 | 245,000.00 | 245,000.00 | 1.00 | 245,000.00 | 245,000.00 | - | Орон нутгийн өмчийн алба |
| 31 | Тээвэр авто замын газар | Note book компьютер | 4.0 | 2012/10/07 | 1,050,000.00 | 1,050,000.00 | 1.00 | 1,050,000.00 | 590,625.00 | 459,375.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 32 | Тээвэр авто замын газар | Note book компьютер | 5.0 | 2013/12/23 | 1,250,000.00 | 1,250,000.00 | 1.00 | 1,250,000.00 | 249,999.96 | 1,000,000.04 | Орон нутгийн өмчийн алба |
| 33 | Тээвэр авто замын газар | Epson LQ 590 Кассын принтер | 4.0 | 2012/12/12 | 609,000.00 | 609,000.00 | 1.00 | 609,000.00 | 317,187.50 | 291,812.50 | Орон нутгийн өмчийн алба |
| 34 | Тээвэр авто замын газар | Note book компьютер 1200.0 | 4.0 | 2012/12/25 | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1.00 | 1,200,000.00 | 625,000.00 | 575,000.00 | Орон нутгийн өмчийн алба |
| 35 | Тээвэр авто замын газар | Принтер 2165 | 4.0 | 2012/12/25 | 200,000.00 | 200,000.00 | 1.00 | 200,000.00 | 104,166.75 | 95,833.25 | Орон нутгийн өмчийн алба |
| 36 | Тээвэр авто замын газар | Принтер 2165 | 5.0 | 2013/12/23 | 259,000.00 | 259,000.00 | 1.00 | 259,000.00 | 51,799.98 | 207,200.02 | Орон нутгийн өмчийн алба |
| 37 | Тээвэр авто замын газар | Компьютер dell | 4.0 | 2012/12/10 | 979,000.00 | 979,000.00 | 1.00 | 979,000.00 | 611,874.90 | 367,125.10 | Орон нутгийн өмчийн алба |
| 38 | Тээвэр авто замын газар | 4-н үйлдэлт принтер | 4.0 | 2012/12/10 | 299,900.00 | 299,900.00 | 1.00 | 299,900.00 | 187,437.60 | 112,462.40 | Орон нутгийн өмчийн алба |
| 39 | Тээвэр авто замын газар | Стекер принтер | 4.0 | 2012/12/10 | 89,000.00 | 89,000.00 | 1.00 | 89,000.00 | 55,625.10 | 33,374.90 | Орон нутгийн өмчийн алба |
| | | | | | | 7,644,900.00 | 13.00 | 7,644,900.00 | 4,502,716.79 | 3,142,183.21 | |
| | **Нийт үндсэн хөрөнгийн дүн** | | | | | 32,966,272.00 | 44.00 | 32,966,272.00 | 13,642,152.51 | 19,324,119.49 | |

OoO

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
42 дугаар тогтоолын хавсралтаар хавсралт

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛСЭН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Байгууллагын нэр | Нэр төрөл | Ашиглах жил | Огноо | Нэгжийн үнэ | Тоо | Бүгд үнэ | Хур элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тээвэр авто замын газар | Бичгийн ширээ | 10.0 | 2009/11/01 | 188,000.00 | 1.0 | 188,000.00 | 97,133.00 | 90,867.00 | Аймгийн ЗДТГ |
| 2 | Тээвэр авто замын газар | Сандал 96.0 | 10.0 | 2012/11/14 | 96,000.00 | 1.0 | 96,000.00 | 20,800.00 | 75,200.00 | Аймгийн ЗДТГ |
| 3 | Тээвэр авто замын газар | Стандарт норм дүрэм техникийн шаардлага | - | 2013/12/19 | 51,250.00 | 8.0 | 410,000.00 | - | 410,000.00 | Аймгийн ЗДТГ |
| 4 | Тээвэр авто замын газар | Баянхонгор авто замын сүлжээ зураг | - | 2013/12/10 | 2,000,000.00 | 1.0 | 2,000,000.00 | - | 2,000,000.00 | Аймгийн ЗДТГ |
| 5 | Тээвэр авто замын газар | GPS программ | 5.0 | 2012/10/02 | 100,000.00 | 2.0 | 200,000.00 | 89,999.91 | 110,000.09 | Аймгийн ЗДТГ |
| 6 | Тээвэр авто замын газар | Замын программ | 4.0 | 2013/12/01 | 650,000.00 | 1.0 | 650,000.00 | 176,041.71 | 473,958.29 | Аймгийн ЗДТГ |
| 7 | Тээвэр авто замын газар | Note book компьютер | 4.0 | 2012/10/02 | 600,000.00 | 1.00 | 600,000.00 | 337,500.00 | 262,500.00 | Аймгийн ЗДТГ |
| 8 | Тээвэр авто замын газар | GPS аппарад | 4.0 | 2012/09/16 | 1,250,000.00 | 2.00 | 2,500,000.00 | 1,458,333.24 | 1,041,666.76 | Аймгийн ЗДТГ |
| 9 | Тээвэр авто замын газар | Принтер 2165 | 5.0 | 2013/12/23 | 259,000.00 | 1.00 | 259,000.00 | 51,799.98 | 207,200.02 | Аймгийн ЗДТГ |
| 10 | Тээвэр авто замын газар | Таодмет ком | 4.0 | 2013/12/10 | 5,880,000.00 | 1.00 | 5,880,000.00 | 1,592,500.00 | 4,287,500.00 | Аймгийн ЗДТГ |
| 11 | Тээвэр авто замын газар | Невлер | 5.0 | 2013/12/10 | 1,320,000.00 | 1.00 | 1,320,000.00 | 286,000.00 | 1,034,000.00 | Аймгийн ЗДТГ |
| | Нийт үндсэн хөрөнгийн дүн | | | | | - | 14,103,000.00 | 4,110,107.84 | 9,992,892.16 | |

ОоО

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
42 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

## ТЭЭВЭР АВТО ЗАМЫН ГАЗРЫН АКТЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Сумын нэр | Байгууллагын нэр | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ | Элэгдэл | Үлдэгдэл өртөг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Зургийн аппарад | 2013/07/17 | 1.0 | 100,000.00 | 100000 | 14166.61 | 85833.39 | Ашиглах боломжгүй |
| 2 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Диван ор | 2009/09/29 | 1.0 | 65,000.00 | 65000 | 34666.83 | 30333.17 | Ашиглах боломжгүй |
| 3 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Хаяг | 2009/12/01 | 1.0 | 55,000.00 | 55000 | 27958.17 | 27041.83 | Ашиглах боломжгүй |
| 4 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | МР | 2010/12/29 | 1.0 | 28,000.00 | 28000 | 11432.84 | 16567.16 | Ашиглах боломжгүй |
| 5 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Тоос сорогч | 2010/12/29 | 1.0 | 100,000.00 | 100000 | 40833.84 | 59166.16 | Ашиглах боломжгүй |
| 6 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Буйдан | 2012/12/24 | 1.0 | 349,000.00 | 349000 | 72708.25 | 276291.75 | Ашиглах боломжгүй |
| 7 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Компьютер | 2007/12/01 | 1.0 | 549,028.27 | 549028.27 | 549028.27 | 0 | Ашиглах боломжгүй |
| 8 | Баянхонгор | Тээвэр авто замын газар | Принтер LQ | 2007/12/01 | 1.0 | 383,160.00 | 383160 | 383160 | 0 | Ашиглах боломжгүй |
| | | | | | | | 1629188.27 | 1133954.81 | 495233.46 | |

OoO

139

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 13 өдөр Дугаар 43 Номгон

Журам шинэчлэн батлах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, мөн хуулийн 29, 31 дүгээр зүйлүүдийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн нийтлэг журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг мөрдөж ажиллахыг сумдын ИТХ-ын дарга нарт зөвлөж. Засаг дарга, орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газрын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 52 дугаар тогтоол, 2009 оны 108 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.ШИРМЭН

D;2015on/ITHT_Togtool2015

0114487

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 43 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

# ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ДУУДЛАГААР ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ, АКТЛАХ ЖУРАМ

## Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид "эд хөрөнгө" гэх/-ийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлаж устгах, данснаас хасах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, эсхүл хуулийн этгээд, хувь хүнээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

1.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, бүрэн бүтэн байдлыг хангах талаар тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээж аймгийн ИТХ-ын Өмчийн албатай байгуулсан ". Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний дагуу зохицуулна.

1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах түрээслүүлэхдээ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан холбогдох журам зааврыг баримтлана.

1.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл элэгдлийн хэмжээ нь дуусаагүй боловч ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах саналыг энэ журмын 1.9, 1.10, 1.11, 1.12-д заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэн Орон нутгийн өмчийн албанд ирүүлнэ.

1.6. Орон нутгийн өмчийн алба нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хүлээн авч хянан үзээд эд хөрөнгийг олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах шийдвэрийн аль нэгийг гаргуулна.

1.7 Тухайн байгууллагын хувьд илүүдэлтэй буюу ашиглагддаггүй, эсхүл сэргээн засварлаж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашигтай болох нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг зөвхөн дуудлагаар худалдахаар шийдвэрлэж, худалдах доод үнийг энэ журмын 6.3 дахь заалтыг баримтлан тогтооно.

1.8. Эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг шийдвэрт заасан хугацаанд

холбогдох материалын хамт аймгийн ИТХ-ын Өмчийн албанд ирүүлэх үүрэг хүлээнэ.

1.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай саналаа Өмчийн албанд ирүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримтыг бүрдүүлнэ:
а/ хуулийн этгээдийн эрх барих болон харъяа дээд байгууллагын зөвшөөрөл;
б/ худалдан авах эх үүсвэр санхүүжилтийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр, хуваарилагдсан төсөв;
в/ хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт;
г/ мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;
д/ эдийн засгийн тооцоо, үндэслэл;
е/ худалдах, худалдан авах, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, худалдах доод үнийн санал;
ё/ балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн зөвшөөрөл, хүсэлт;
ж/ ашиглалтын хугацаа, элэгдлийн хэмжээ дуусаагүй боловч эвдрэл, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтэл болон хуулийн этгээдэд учирсан хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаас тогтоосон акт дүгнэлт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;
з/ үл хөдлөх хөрөнгийн хувьд хөрөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ;
и/ үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл;
й/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсэгийг хураах талаар Цагдаагийн байгууллагын албан ёсны зөвшөөрөл;
к/ бусад шаардлагатай баримт, материал.

1.10. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэ журмын 1.9-д зааснаас гадна доорхи мэдээллийг ирүүлнэ:
а/ эзэмших болон ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх болон ашиглуулах гэрээ, барилга техникийн төлөв байдлын талаархи мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, ашиглалт, их болон урсгал засвар, эд хөрөнгийн хариуцлагын /ээл, өрийн барьцаа, эрх бүхий байгууллагын шийдвэр/ талаархи мэдээлэл, барилгын паспорт, кадастрын зураг, орчны тойм зураг, байгуулалтын /план/ болон гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн сүлжээний техникийн зураг, бусад бичиг баримт.

1.11. Тээврийн хэрэгслийн хувьд энэ журмын 1.9-д зааснаас гадна доорхи мэдээллийг ирүүлнэ:
а/ тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон бусад техникийн баримт бичгийн хуулбар, техникийн үзүүлэлт, 4 талаас нь авсан өнгөт фото зураг;
б/ төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн талаархи мэдээлэл, холбогдох баримт;
в/ ашиглалтын явцад хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ;
г/ балансын үнэ /анхны болон үлдэгдэл үнэ, ашиглалтын явцад байгуулсан элэгдлийн дүн/, ашиглагдах үеийн сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардал, /шинээр тавьсан сэлбэгийн нэр төрөл, үнийн дүн/

1.12. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэ журмын 1.9, 1.11-д зааснаас гадна доорхи мэдээллийг ирүүлнэ:
а/ механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар;
б/ бусад шаардлагатай материал.
1.13. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн харилцааны зарим асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас гадна Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын гэрээ, конвенц болон Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрээр тусгайлан зохицуулсан тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.
1.14. Энэхүү журам нь өмч хувьчлалын хөтөлбөрөөр хуулийн дагуу явуулах дуудлагын худалдаанд хамаарахгүй.

## Хоёр. ОРОН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган, зорилтын саналын хамт 3 дугаар сарын 1-ний дотор, төсвийн ерөнхийлэн захирагчид дараа оны санхүүгийн жил эхлэхээс 6 сарын өмнө буюу /жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор/ аймгийн ИТХ-ын Өмчийн албанд захиалгаа ирүүлнэ.
2.2. Эд хөрөнгийн захиалга, жагсаалтад тоо хэмжээ, үнийн дүн /үнэ/, хүчин чадал, техникийн үзүүлэлт, бусад шаардлагатай тайлбар тодорхойлолтыг тусгана.
2.3. Өмчийн алба нь захиалга, жагсаалтыг нягтлан шалгаж, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран зардлын дээд хязгаарыг тогтоож, зохих шийдвэрийг гаргана.
2.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө худалдан авах үнийн дээд хязгаарыг аймгийн ИТХ-ын Өмчийн алба тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэр, тэдгээрийн хэрэглэлийн тухайд тогтоосон тоо, төрлийг баримтлана.
2.5. Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар нь улсын төсөвт эх үүсвэр нь тусгагдаагүй боловч ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар үндсэн хөрөнгө худалдаж авах тохиолдолд үндэслэл, санхүүгийн эх үүсвэрээ эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлсний үндсэн дээр Орон нутгийн өмчийн албанд саналаа тавьж болно.
2.6. Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд эх үүсвэр нь батлагдаагүй боловч Эрчим хүч, уул уурхай, авто замын салбарын байгууллагуудын хувьд онцгой байдал үүссэн, ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар үндсэн хөрөнгө худалдан авах тохиолдолд тодорхой үндэслэл, хөрөнгийн эх үүсвэрээ шийдвэрлэн Аймгийн ИТХ-д саналаа тавьж зохих зөвшөөрөл авна.
2.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө, хандив, банкны зээл, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах, нийгэмчилсэн, өр төлбөрт тооцон авсан, дайчилсан буюу хураан авах журмаар эд хөрөнгө олж авбал энэ тухай аймгийн ИТХ-ын өмчийн албанд мэдэгдэж, уг хөрөнгийг бүртгэлд тусгана.
2.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, өөрийн чиг үүрэгт өөрчлөлт орсон, хариуцах ажлын цар хүрээ өргөжсөн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан үйлчилгээний автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа аймгийн ИТХ-д тавьж шийдвэрлүүлнэ.

2.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд автомашин шинээр худалдан авах болон илүүдэлтэй буюу ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах саналаа хамтад нь тавьж шийдвэрлүүлнэ.

## Гурав. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОЛЖ АВСАН ЭД ХӨРӨНГИЙГ БҮРТГЭХ

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна.
3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд Орон нутгийн өмчийн албыг төлөөлөн ажилласан мэргэжилтэн хүлээн авсан актыг үндэслэн тухайн барилга, объектын санхүүгийн тайланд тусгах үнэ өртгийг тооцон, эзэмшигч байгууллагыг тогтоож, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.
3.3. Гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдийн албан ёсны зөвшөөрлийг авсны үндсэн дээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцна.
3.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч шууд данс бүртгэлдээ тусгана.
3.5. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй, маргаантай тохиолдолд Орон нутгийн өмчийн албанд асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.
3.6. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээлгэн өгөх, УИХ-ын тогтоол болон Төрийн өмчийн хорооны тогтоолоор Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжин ирсэн хөрөнгийг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэхдээ дараахь материалыг бүрдүүлсэн байна.
а/ УИХ болон ТӨХ-ны тогтоол шийдвэр, аймгийн ИТХ-ын шийдвэр, уг шийдвэрт шилжүүлэх хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээ, нэр төрөл, байршил, чанар байдлыг тодорхой тусгасан байх;
б/ Шилжүүлэн авах үндсэн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлдээ тусгах байгууллагад энэ талаар мэдэгдэж, зөвшөөрөл, дэмжлэг авсан байхаас гадна өмч эзэмшигч байгууллагын саналыг авсан байх.

## Дөрөв. ЭД ХӨРӨНГИЙГ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ

4.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх тухай болон, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах саналтай байгууллагын удирдлага, өмч эзэмшигч байгууллагаас албан ёсоор зөвшөөрөл авч, холбогдох материалыг энэ журмын 1.9-д заасны дагуу бүрдүүлэн ирүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрт заасны дагуу хэрэгжүүлж, баланс тайланд хөдлөл өөрчлөлт хийнэ.

4.2. Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-т заасны дагуу шилжүүлж болно.

4.3. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шилжүүлж авсан байгууллага хариуцна.

**Тав. ҮНДСЭН ХӨРӨНГИЙГ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ**

5.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн хөрөнгө акталж данснаас хасах тухай асуудлаа жилд хоёроос илүүгүй удаа аймгийн Орон нутгийн өмчийн албанд ирүүлж зохих шийдвэр гарсны дараа хэрэгжүүлнэ.

5.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараахь тохиолдолд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр данснаас хасна. Үүнд:

5.2.1. Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ нөхсөн, эсхүл ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;

5.2.2. техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон эд хөрөнгө;

5.2.3. Балансын үнээ бүрэн нөхөөгүй болсвч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгө;

5.2.4. ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгө.

5.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа Орон нутгийн өмчийн албанд ирүүлэхдээ энэхүү журмын 1.9-д заасан мэдээллээс гадна дор дурдсан зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна:

а/ данснаас хасах эд хөрөнгийн тодорхойлолт, хүсэлт;
б/ тоо хэмжээ;
в/ данснаас хасах болсон шалтгаан;
г/ уг эд хөрөнгийг акталж устгах, тухай санал, хүсэлт;
д/ өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;
е/ байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт дүгнэлт.

5.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хянан үзэж, шийдвэр гаргана. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн

байлгах асуудлыг байгууллагын удирдлага хариуцаж, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдвал хариуцлагыг зохих хууль тогтоомжийн хүрээнд Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/, нягтлан бодогч, эд ажхуйн нярав нар хүлээнэ.
5.5. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа дараахь хэлбэрээр шийдвэрлэнэ:
а/ эд хөрөнгийг худалдах;
б/ бусад төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх;
в/ сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах;
г/ шууд устгах;
д/ өөрийн эзэмшилд байгаа газраа цаашид ямар зориулалтаар ашиглах талаар эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ;
е/ газар дээрхи болон газар доорхи барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх.
5.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлөөрөө хэлэлцэн шийдвэрлэж, гүйцэтгэлийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана.
5.7 Сумдын төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, барилга байгууламж, газар, худаг ус, уст цэг, услалтын систем, оюуны өмч биет бус хөрөнгө зэргийг актлахдаа журамд заасан баримтыг бүрдүүлсэн нөхцөлд сумын ИТХ-ын хүсэлтийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гаргана.
5.8 Сумдын төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл, ном, тавилга эд хогшил, бусад хөрөнгийг актлах устгах эрхийг аймгийн ИТХ-тай зөвшилцсөний үндсэн дээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчид эдлэх бөгөөд актлах устгалтаас орох орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ. Энэхүү журмын заалтыг мөрдөн ажиллана.

## Зургаа. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ЭД ХӨРӨНГИЙН ДУУДЛАГЫН ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

6.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг гапцуу дуудлага худалдаагаар худалдана.
6.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн даргын тушаалаар томилно.
6.3. Дуудлагаар худалдах хөрөнгийн худалдах доод үнэ тогтоох.
6.3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 83 дугаар тогтоолоор байгуулсан үнэлгээний комисс тогтооно.
а/ Балансын болон үлдэгдэл өртөг;
б/ Сүүлийн их засварын капиталжуулсан зардал;
в/ Үл хөдлөх хөрөнгө оршин байгаа нутаг дэвсгэрийн газрын сангийн зэрэглэлийн нэгж талбайн суурь үнэлгээ;
г/ Үл хөдлөх хөрөнгийн бодит үнэлгээ;

д/ Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
е/ Зах зээлийн судалгаа эрэлт, хэрэгцээ биет байдал.
ж/Барилгын хувийн хэргийн хөтлөлт /барилгад хийсэн их болон урсгал засварын эх үүсвэр хийсэн ажлын гүйцэтгэлийг үзэх/
6.3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх эд хөрөнгийг худалдах доод үнэ буюу үнэлгээг тогтоохдоо дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 83 дугаар тогтоолоор байгуулсан үнэлгээний комисс тогтооно:
а/ Гарал үүсэл, зориулалт /Автомашины гэрчилгээ/
б/ Ашигласан хугацаа;
в/ Хөрөнгийн ерөнхий болон техникийн төлөв байдал /биет байдал/;
г/ Балансын болон үлдэгдэл үнэ, ашиглалтын үеийн элэгдэл;
д/ Ашиглах үеийн сүүлийн 1 жилийн сэргээн босголтын зардал;
е/ Зах зээлийн судалгаа, эрэлт, хэрэгцээ.
ж/Автомашины хувийн хэргийн хөтлөлтийг санхүүгийн анхан шатны баримттай тулган баталгаажуулах
з/ Автомашин болон бусад үнэлэх үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн алба болон тодорхой харуул хамгаалалттай төрийн байгууллагын хашаанд ба агуулахад байрлуулсаны дараа үнэлгээг хийнэ. /автомашины 4 талаас авсан фото зураг хавсаргана/
6.4. Дуудлагын худалдаа зарлах, зохион байгуулах.
6.4.1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор дуудлага худалдааны талаарх зар мэдээг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу өдөр тутмын сонин, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон аймгийн ИТХ-ын цахим хуудсанд байршуулан нийтэд зарлан мэдээлнэ. /Маягт 1/
6.4.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн дуудлагын худалдааг зөвхөн аймгийн ИТХ-ын өмчийн албаны байранд зохион байгуулна.
6.4.3. Хөдөө орон нутагт байршилтай орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автомашины дуудлагын худалдааг аймгийн ИТХ-д хүсэлт гаргаж, зөвшөөрөл авсан дараа Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4.3 дах заалтын дагуу сумын ИТХ-ын Тэргүүлэгчид шийдвэр гаргаж болно. Дуудлагын худалдааны зар мэдээг, өмч эзэмшигч хуулийн этгээд эд хөрөнгө худалдах шийдвэрийг үндэслэн өөрөө зарлан мэдээлж, мөн энэ тухай мэдээллээ аймгийн ИТХ-ын цахим хуудсанд байршуулж, энэхүү журмын дагуу зохион байгуулна. Автомашины дуудлагын худалдааг орон нутагт явуулахгүй гэж үзвэл эзэмшигч байгууллага зардлаа гарган аймгийн Орон нутгийн өмчийн албанд хүлээлгэн өгч шийдвэр гарсаны дараа аймагт дуудлага худалдааг зохион байгуулна.
6.4.4. Дуудлагын худалдаа явуулах тухай зар мэдээнд дараах зүйлийг тусгана. Үүнд:
а/ худалдах эд хөрөнгийн нэр төрөл, худалдах доод үнэ;
б/ дуудлагын худалдаа явуулах газар байршил, хаяг, эхлэх он, сар, өдөр, цаг;
в/ дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ, дэнчин тушаасан баримт;
г/ дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэх журам, хугацаа;
д/ барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн тодорхойлолт, тоо хэмжээ;
е/ лавлагаа авах утасны дугаар.

145

6.4.5.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгө эхний дуудлагын худалдаагаар зарагдаагүй бол дахин дуудлагын худалдаа зарлан явуулж, мөн зарагдаагүй тохиолдолд худалдах доод үнийг **20** хүртэл хувиар буурулан гурав дахь дуудлагын худалдаа зарлах, эсхүл өмч эзэмшигч байгууллагын саналыг харгалзан акталж данснаас хасах асуудлыг аймгийн ИТХ шийдвэрлэнэ.

6.4.6. Акталж, данснаас хасах шийдвэрт устгалаас орлуулах орлогын доод хэмжээг тогтоон өгч, тухайн өмч эзэмшигч байгууллагын удирдлага, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтын дор хэрэгжүүлнэ.

6.4.7. Дуудлагын худалдаанаас олсон орлогыг орон нутгийн өмчит байгууллагын хувьд 100,0 хувь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх буюу Орон нутгийн өмчийн алба орлогын төлөвлөгөө төсөвлөсөн бол өмчийн албаны дансанд тус тус төвлөрүүлнэ.

***6.5. Дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэх***

6.5.1. Дуудлагын худалдааг эрхлэн явуулах "Ажлын хэсэг" санал авах хайрцгийг бэлэн болгож, дуудлагын худалдааг зохион байгуулахаар товлосон газар байрлуулна.

6.5.2. Дуудлагын худалдаанд оролцохыг хүсэгчид нь "Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт" гаргах /Маягт-2/-ийг үнэн зөв, гаргацтай бүрэн гүйцэд бөглөх бөгөөд түүнээс үүсэх хариуцлагыг оролцогч өөрөө хариуцна.

6.5.3. Дуудлагын худалдаанд оролцохыг хүсэгчид дараахь материалыг бүрдүүлнэ:

***Иргэний хувьд:***

а/ Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт гаргах маягт;
б/ Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
в/ Дэнчин тушаасан баримт;
г/ Дуудлагын худалдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оруулах бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэл, иргэний үнэмлэх.
д/ Дуудлага худалдаанд оролцох иргэн 40,0 мянган төгрөгийн хураамж төлсөн баримт
е/ Ажиглагчаар оролцогч иргэний хувьд 5,0 мянган төгрөг тушаасан баримт

*Хуулийн этгээдийн хувьд:*

а/ Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт гаргах маягт;
б/ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
в/ Дэнчин тушаасан баримт;
г/ Дуудлагын худалдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оруулах шийдвэр, эсхүл нотариатаар баталгаажуулсан итгэмжлэл.
д/ Дуудлага худалдаанд оролцох байгууллага 60,0 мянган төгрөгийн хураамж төлсөн баримт
е/ Ажиглагчаар оролцохоор ирсэн байгууллагын төлөөлөлийн хувьд иргэний үнэмлэх, ажиглагчаар оролцохыг зөвшөөрсөн байгууллагын даргын шийдвэр 10,0 мянган төгрөг тушаасан баримт

6.6 Дуудлага худалдааны хураамжийг зарцуулах

6.6.1 Дуудлага худалдаанд оролцох иргэн, хуулийн этгээдийн төлсөн хураамж, ажиглагчийн мөнгийг дуудлага худалдааны зар, бичиг хэргийн зардалд зарцуулж баримтын бүрдлийг дуудлага худалдааны баримтанд хавсаргана.

7.1. Дэнчин

7.1.1. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдах доод үнэ 10.000.000 (Арван сая) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 25-30 хувиар, 10.000.001 (Арван сая нэг) төгрөгөөс дээш бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 20 хувиар тогтооно. Үл хөдлөх хөрөнгийн дэнчингийн хэмжээг шаардлагатай бол аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчидээс тухай бүр тогтоож болно.
7.1.2. Дэнчинг Орон нутгийн өмчийн албаны данс болон Хөрөнгө худалдан борлуулсаны орлого дансанд тус тус бэлнээр буюу шилжүүлгээр тушаана.
7.1.3. "Худалдах, худалдан авах гэрээ" /Маягт 3/-нд дуудлагын худалдаанд ялагчийн урьдчилан төлсөн дэнчинг худалдан авсан эд хөрөнгийн үнийн дүнгээс хасч тооцон, тушаах мөнгөний хэмжээ, төлбөр хийх хугацааг тусган өмч эзэмшигч хуулийн этгээдийн төлөөлөгч, ялагчтай байгуулна.
7.1.4. Дуудлагын худалдаанд ялагчаар шалгараагүй оролцогчийн дэнчинг ажлын 3 өдрийн дотор тухайн дуудлага худалдаанд оролцсон орон нутгийн өмчийн ажилтны тодорхойлолтыг үндэслэн буцаан олгоно.
7.1.5. Дуудлагын худалдаанд ялагч, худалдан авсан эд хөрөнгийн төлбөрийг Орон нутгийн өмчийн алба буюу хөрөнгө худалдан борлуулсаны орлого дансанд бэлнээр буюу шилжүүлгээр хуульд заасан хугацаанд багтаан тушаах бөгөөд төлөөгүй бол дэнчинг орон нутгийн төсвийн орлого болгож, худалдан авах эрхийг удаах үнийн санал гаргасан оролцогчид санал болгоно.
7.1.6 Сумдын төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд үнэ тогтоох, шилжүүлэх, худалдах эрхийг аймгийн ИТХ-тай зөвшилцсений үндсэн дээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчид эдлэх бөгөөд дуудлага худалдааг энэхүү журмын дагуу зохион байгуулж хөрөнгө худалдан борлуулсаны орлогыг аймаг ба сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ. Энэхүү журмын заалтыг мөрдөн ажиллана.

8.1. Дуудлагын худалдааны үнэ хаялцах хязгаарыг тогтоох
8.1.1. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдах доод үнэ 10.000.000 (Арван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 100.000 (Нэг зуун мянган) төгрөг, дээд хязгаар 150.000 (Нэг зуун тавин мянган) төгрөг байна.
8.1.2. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдах доод үнэ 10.000.001 (Арван сая нэг) төгрөгөөс дээш бол үнэ хаялцах доод хязгаар 200,000/Хоёр зуун мянгаас/ -500,000 (Таван зуун мянган) төгрөг, дээд хязгаар нь дэнчингийн хэмжээтэй тэнцүү буюу 1,000,000 (Нэг саяаас)-1500000/Нэг сая таван зуун мянган / төгрөг байна.
9.1. Дуудлагын худалдааг зохион байгуулах Ажлын хэсгийн эрх, үүрэг
9.1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн дуудлагын худалдааг энэхүү журмын 6.2 дахь хэсэгт заасан Ажлын хэсэг зохион байгуулж явуулна.
9.1.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд доорхи төлөөллийг заавал оруулна.
а/ Төрийн өмчийн хорооны төлөөлөгч;
б/ Хөтлөгч (Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн);
в/ Тэмдэглэл хөтлөгч (Өмч эзэмшигч хуулийн этгээдийн ажилтан);
9.1.3. Орон нутагт байршилтай хуулийн этгээдийн эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах комиссыг тухайн Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр дараахь бүрэлдэхүүнтэй томилно:
а/ Орон нутгийн өмчийн төлөөлөгч (Тухайн орон нутаг дахь өмчийн мэргэжилтэн)
б/ Хөтлөгч ( Аймгийн ИТХ-ын ахлах буюу ахлын албаны мэргэжилтэн);
в/ Тэмдэглэл хөтлөгч (Өмч эзэмшигч хуулийн этгээдийн ажилтан).
9.1.4. Ажлын хэсэг дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

а/ Дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэж, баримт бичгийг шалгасны эцэст оролцогч бүрт дугаар бүхий пайз олгоно;
б/ Дуудлагын худалдаанд нэг ч этгээд ирээгүй, эсхүл хөрөөс доош этгээд ирсэн, худалдах доод үнээс дээш үнийн санал гараагүй бол дуудлагын худалдааг явагдаагүйд тооцон, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.
9.1.5. Орон нутгийн өмчийн хорооны төлөөлөгч дараах эрх, үүрэгтэй:
а/ Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулахтай холбогдсон хууль тогтоомж, журмын заалт, эд хөрөнгө худалдах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр, дуудлагын худалдааг зохион байгуулан явуулах Ажлын хэсгийг томилсон тухай шийдвэрийг тус тус танилцуулж, оролцогчдод дуудлагын худалдаа эхэлснийг мэдэгдэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ;
б/ Дуудлагын худалдаанд оролцогчдоос холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллахыг шаардах, дуудлага худалдааны явцад оролцогчдоос хууль журмыг зөрчиж, үнэ хаялцуулах өрсөлдөөнийг хязгаарласан, үнэгүйдүүлэх үйлдэл илт илэрч байгаа тохиолдолд дуудлагын худалдааг зогсоож, хүчингүй болгон, энэ тухай дуудлагын худалдааны явцын тэмдэглэлд тодорхой тусгуулах.
9.1.6 Дуудлагын худалдааны хөтлөгч нь дараахь эрх, үүрэгтэй:
а/ үнэ хаялцах доод болон дээд хязгаарыг зарлаж, дуудлагын худалдааны тэмдэглэлд тусгах;
б/ дуудлагын худалдаа эхэлснийг зарлан мэдээлсний дараа үнэ хаялцах ажиллагааг тусгай дохиогоор эхлэн дуудлагын худалдаанд оролцогчдын үнийн саналыг пайз өргөсөн дарааллаар дуудах;
в/ дуудлагын худалдаанд оролцогчийн үнийн саналыг гурван удаа давтаж хэлэх;
г/ хамгийн сүүлд гарсан үнийн саналыг гурван удаа давтан "буулаа" нэг, хоёр, гурав гэж тоолсны дараа шинээр үнийн санал гараагүй бол тусгай дохиогоор дуусгавар болгон ялагчийг зарлан мэдээлэх;
д/ Орон нутгийн өмчийн төлөөлөгч дуудлагын худалдааны тэмдэглэлийг хянан үзсэний дараа тэмдэглэлд гарын үсэг зурах;
е/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн дагуу үүрэг хүлээнэ.
9.1.7. Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч нь дараахь эрх, үүрэгтэй:
а/ Дуудлагын худалдаанд оролцогчдыг бүртгэх;
б/ Дуудлагын худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх;
в/ Дуудлагын худалдааны үнэ хаялцах доод болон дээд хязгаарыг дуудлагын худалдааны тэмдэглэлд тусгах;
г/ Дуудлагын худалдаанд оролцогчдын үнийн саналыг пайз өргөсөн дарааллаар явцын тэмдэглэлд бичих;
д/ Орон нутгийн өмчийн төлөөлөгч дуудлагын худалдааны тэмдэглэлийг хянан үзсэний дараа тэмдэглэлд гарын үсэг зурах;
е/ Дуудлагын худалдааны явцын тэмдэглэл /Маягт-4/-д Орон нутгийн өмчийн төлөөлөгч, хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр бол баталгаажина.
9.2 Дуудлагын худалдааг дахин явуулах
9.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон энэ журамд заасан үндэслэлээр дуудлагын худалдаа явагдаагүй буюу хууль зөрчин явуулсанд тооцсон бол дуудлага худалдааг дахин явуулна.

147

9.2.2 Дуудлага худалдаа дахин явуулах тухай шийдвэрийг АИТХ-ыг Тэргүүлэгчдийн гаргасан тогтоолыг үндэслэн дахин дуудлага худалдаа явуулахаас 14 хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.
9.2.3 Дуудлага худалдаа дахин явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон энэхүү журмыг баримтална.
9.2.4 Дуудлагын худалдаанд 2-оос дээш оролцогч байсан боловч нэгээс бусад нь үнэ хаялцаагүй бол өрсөлдөгчгүй гэж үзэн дуудлагын худалдааг хүчингүйд тооцон дахин явуулна.
9.2.5 Дуудлага худалдаа явуулах хөрөнгийн доод үнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоосон үнээр 2 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулах бөгөөд 3 дахь буюу түүнээс дээш удаа дуудлага худалдаа зарласан нөхцөлд тухай бүр доод үнийг 20 хувь буулгаж дуудлага худалдааг зохион байгуулах бөгөөд оролцогч ирээгүй бол хөрөнгийг актлах шийдвэр гаргуулна.

## Долоо. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХУДАЛДАХ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ

10.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, актлаж устгах талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс гарсан шийдвэрийг өмч хамгаалах Байгнын зөвлөл хэрэгжүүлж, тухайн хуулийн этгээдийн дарга (захирал) хяналт тавина.
10.2. Эд хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.
10.3. Эд хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлах шийдвэрийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих үүргийг тухайн хуулийн этгээдийн дарга (захирал) хариуцна.
10.4. Эд хөрөнгө олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлнэ.
10.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг жил бүрийн эцэст "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хавсралтын дагуу гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн албанд ирүүлнэ.

## Найм. ХАРИУЦЛАГА

11.1. Энэ журмыг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд заасанаар хариуцлага хүлээлгэнэ.
11. 2 . Энэ журам болон эд хөрөнгө олж авах, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах, бүртгэхтэй холбогдон гарсан бусад хууль тогтоомж, журмыг зөрчсөнөөс Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд болон төсөвт учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.
11.3 Дуудлагын худалдааны явцад үүссэн маргааныг аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчид шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд хандана.

## Есө. БУСАД

12.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл байгуулахад тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгийн данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх тухай хүсэлтийг Орон нутгийн өмчийн албанд тавьж зөвшөөрөл авсаны үндсэн дээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гаргуулан хөрөнгийн хөдлөлийг хийж бүртгэлд тусгана.

12.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрх мэдлийн хүрээнд хамаарах төсөвт байгууллагын хооронд үндсэн хөрөнгө шилжүүлэх асуудлыг тухайн төвлөрүүлэн захирагчийн хүсэлтийг үндэслэн аймгийн ИТХ албан бичгээр зөвшөөрөл олгоно.

12.3. Үндсэн хөрөнгийн үнэлгээний залруулга болон дахин үнэлгээг Сангийн яамны холбогдох шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу аймгийн ИТХ-аас албан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүгийн тайланд тусгана.

12.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тогтоохдоо Татварын болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан журмын 1, 2 дугаар хавсралтыг баримтална.

12.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бэлтгэх ажлыг журамлах тухай" Засгийн газрын 2009 оны 234 дүгээр тогтоолыг мөрдлөг болгон ажиллана.

12.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашин, механизмын эдэлгээний нөөцийн доод хязгаарыг тогтоохдоо Дэд бүтцийн (хуучнаар) сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" журмыг баримтална.

12.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх барих дээд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар эд хөрөнгө олж авах, бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах тухай асуудлыг хэлэлцэхэд энэ журмыг удирдлага болгоно.

12.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөл үйл ажиллагаандаа энэ журмыг баримтлан ажиллана.

oOo

Маягт -1

## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 20... оны .... дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр "........"Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ...... улсад үйлдвэрлэж, ........ онд ашиглалтад орсон, ...... маркийн, .................. мотортой, ............ арлын дугаар, ............ тоот улсын бүртгэлийн дугаартай, нийт ..... км/цаг явсан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдана.
Дуудлагын худалдаа 20... оны ...... дугаар сарын ......-ний өдрийн ....... цагт аймгийн /Орон нутгийн өмчийн алба/-ны давхарын Хурлын танхим ..... /тоот өрөөн/-нд болно.
Дуудлагаар худалдах үл хөдлөх хөрөнгө болон автомашины доод үнэ: ........................ /............................................/ төгрөг
Дэнчингийн хэмжээ: ..................... /..................................................../ төгрөг
Оролцогч дэнчингийн мөнгийг Төрийн сан дахь Орон нутгийн өмчийн албаны тоот данс, эсхүл Хөрөнгө худалдан борлуулсаны орлого................ тоот дансанд тушаасан баримт авчирснаар оролцох эрх авна.

Дуудлагаар худалдах үл хөдлөх хөрөнгө болон автомашиныг өмч эзэмшигч байгууллага дээр очин үзэж болох бөгөөд дуудлагын худалдааны журам, бүртгэх хугацаа, автомашины талаарх мэдээллийг Орон нутгийн өмчийн албаны .............. дугаарын утсаар авна уу.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБА

Маягт-2

## ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ

Дугаар

1. Ямар аж ахуйн нэгжийн эд хөрөнгийн дуудлагын худалдаанд оролцох:

----------------------------------------------------------------------------------------

2. Оролцогчийн овог, нэр ----------------------------------------------------------------

3. Оролцогчийн гэрийн хаяг --------------------------------------------------------------

4. Оролцогчийн регистрийн № -------------------------------------------------------------

5. Зөвлөхийн овог нэр -------------------------------------------------------------------

6. Зөвлөхийн иргэний үнэмлэхийн № ------------------------------------------------------

7. Дэнчингийн хэмжээ ------------------------ /үсгээр/ ----------------------------------

----------------------------------------------------------------------------------------

8. Дэнчинг шилжүүлсэн ---------он -------- сар ------------ өдөр ----------- цаг

9. Оролцогчийн оршин суугаа тодорхой хаяг ----------------------------------------------

----------------------------------------Харилцах утас ----------------------------------

10. Бөглөсөн : он -----------сар -----------өдөр -------- цаг ----------------------

11. Дуудлагын худалдааны нөхцөл болон ------------------------------------------------

/эд хөрөнгийн нэр / танилцсан:

Гарын үсэг ------------------------

Дуудлагын худалдаанд оролцох бүртгэл энэ хүснэгтийг бөглөж, дэнчинг төлсөн баримтын 1 хувь, оролцогчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаж, дугтуйнд хийгээд бүртгэлийн хайрцагт хийнэ.

Хүснэгтэнд бичигдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг бөглөгч бүрэн хариуцах ба алдаатай, буруу бөглөсөн бол дуудлагын худалдаанд орох боломжгүй болохыг анхаарна уу.

ХҮСЭЛТ ГАРГАСАН

он сар өдөр

162

Маягт-3

## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20.... оны .... сарын ...-ны өдөр Дугаар Баянхонгор

### Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Нэг талаас дуудлагын худалдааг зохион байгуулж явуулсан аймгийн ИТХ-ын Орон нутгийн өмчийн алба /Өмч эзэмшигч байгууллагын нэр бичих/ /цаашид "худалдагч" гэх/, нөгөө талаас дуудлагын худалдаанд хамгийн өндөр үнэ өгсөн ......................................................................................................................

.......... тоот хаягаар оршин суух, ........................ иргэний үнэмлэх, ............... регистрийн дугаартай Монгол улсын иргэн ................ овогтой ........................ /цаашид "худалдан авагч" гэх/ нар 20 ... оны ..... дүгээр сарын ......-ний өдөр аймгийн ИТХ-ын Өмчийн албаны /хурлын танхим /... тоот өрөө/-нд явагдсан дуудлагын худалдааны дүнг үндэслэн Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актын хүрээнд дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

1.2. Өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийн нэр:

"......................................"Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ................ юм.

1.3. Худалдан авсан ......................................-ны нийт үнэ ............... /................./ төгрөг.

1.4. Худалдан авагч нь ...................... дуудлагын худалдааны анхны үнэ .................... /......................./ төгрөгийн ..... хувьтай тэнцэх ...................... /........................................./ төгрөгийн дэнчинг Төрийн сан банкин дахь Орон нутгийн өмчийн албаны данс, эсхүл Хөрөнге худалдан борлуулсаны орлого Төрийн сан банкин дахь................. тоот дансанд 20... оны ... дугаар сарын .....-ны өдөр хийсэн болно.

### Хоёр. Гэрээний зүйл, гол нөхцөл

2.1. Энэхүү гэрээгээр худалдан авагч нь худалдсан ......................................-ны үнийг төлөх, худалдагч нь үнийг бүрэн төлсний дараа ......................................-ыг худалдан авагчид шилжүүлэн өгөх үүргийг тус тус хүлээнэ. Худалдан авагчид ......................-ыг хүлээлгэн өгч, энэ тухай актанд талууд гарын үсэг зурснаар ...................... шилжсэнд тооцно.

### Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг

3.1 Худалдан авсан ......................................-ны үнэ ........................ /......................./ төгрөгийг "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 43 дугаар зүйлд заасны дагуу "Худалдах, худалдан авах гэрээ" байгуулсан 20..... оны ...... дүгээр сарын ......-ний өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор буюу 20.... оны ... дүгээр сарын .......-ны өдрийн ажлын цагт багтаан Төрийн сан банкин дахь Орон нутгийн өмчийн албаны данс, эсхүл Хөрөнге худалдан борлуулсаны орлого Төрийн сан банкин дахь................. тоот дансанд Худалдан авагч нь Худалдагчийн дансанд мөнгө шилжүүлсэн өдрийг төлбөр хийсэн өдөрөөр тооцох бөгөөд Худалдан авагч үнэ төлсөн баримтыг өмчийн албанд ирүүлнэ. Худалдан авагчийн гүйцэтгэсэн

төлбөр Худалдагчийн дансанд бүрэн шилжиж орсон өдрийг төлбөр бүрэн төлөгдсөн өдөр гэж тооцно.
3.2 Худалдан авсан .......................................-ны үнийг төгрөгөөр төлнө.
3.3 Худалдан авсан .....................-ны үнийг бүрэн төлснөөр худалдсан ..........................-ыг шилжүүлж авах болон бичиг баримтыг олгохыг шаардах эрхтэй.
3.4 Бусад

**Дөрөв. Худалдагчийн эрх, үүрэг**

4.1 Худалдан авагчаас тавьсан дэнчин ................ /................................../ төгрөгийг үүргийн гүйцэтгэлд оруулан тооцно.
4.2 Худалдан авагчийн төлсөн мөнгө Худалдагчийн дансанд орсноос хойш хуанлийн 7 хоногийн дотор ...................................... акт үйлдэн хүлээлгэн өгнө.
4.3 ............................. хүлээлцсэн актыг тогтоосон загварын дагуу үйлдэн гарын үсгээ зурж, Худалдан авагчийн гарын үсгийг зуруулж, нэг хувийг өөрт нь гардуулна. Энэхүү акт нь гэрээний салшгүй хэсэг мөн бөгөөд түүнийг энэхүү гэрээнд хавсаргана.
4.4 Худалдан авагчийг худалдан авсан ................................ –ны үнийг энэхүү гэрээний 3.1-д заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
4.5 Бусад

**Тав. Хариуцлага**

5.1 Худалдан авагч худалдан авсан ..............................-ны үнийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол худалдаж авах эрхээ алдана.
5.2 Худалдан авагч нь худалдан авсан ..........................-ны үнийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол дэнчинд тавьсан ..................../...................../ төгрөгийг улсын төсвийн орлого болгоно.
5.3 Худалдан авагч нь худалдан авсан ................................-ыг хүлээн аваагүй тохиолдолд тухайн .........................................-ыг хадгалах, хамгаалж арчлахтай холбогдон гарах зардлыг Худалдагчид нөхөн төлнө.
5.4 Худалдан авагч нь тогтоосон хугацаанд худалдан авсан .........................-ыг хүлээн аваагүй тохиолдолд эд хөрөнгө хүлээлцэхээр тогтоосон өдрөөс хойшхи эд хөрөнгийн гэмтлийг худалдагч хариуцахгүй.

**Зургаа. Давагдашгүй хүчин зүйл**

6.1 ................................-ыг шилжүүлэхээс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирлыг Худалдагч хариуцна.
6.2 ..................................-ыг заасан хугацаанд нь хүлээн аваагүй бол хүлээн авах хугацаа өнгөрсний дараа тохиолдсон гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирлыг Худалдан авагч хариуцна.

**Долоо. Бусад**

7.1 Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хувь тус бүр нэгэн адил хүчинтэй байна.
7.2 Гэрээний үүргийн талаар үүссэн маргааныг 2 тал харилцан тохиролцох замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Гэрээ байгуулсан:**

Худалдагчийг төлөөлж: Худалдан авагчийг төлөөлж:
Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга,
эсхүл " Орон нутгийн өмчийн мэргэжилтэн .................. овогтой ...............

этгээдийн албан тушаалтан
Утас, факс: .................................................. Утас: ....................................

Маягт-4

## ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

.. оны ... сарын ..... өдөр Дугаар Баянхонгор

1. Байгууллагын нэр ..................................................

2. Дуудлагын худалдаагаар худалдах эд ..................................................

хөрөнгийн нэр, марк, дугаар, тоо хэмжээ ..................................................
3. Дуудлагын худалдааны тухай ..................................................

зарласан сонины нэр, дугаар, сар өдөр ..................................................
а/ Дуудлагын худалдаа явагдсан газар, ..................................................
он сар, өдөр, цаг минут ..................................................
4. Дуудлагын худалдааны доод үнэ/................ мян төгрөг

/үсгээр/ ..................................................төгрөг
а/ Дэнчингийн хэмжээ /мян төгрөгөөр/....................төгрөг /үсгээр ..................................................
5. Оролцогчдын нэр

1. ..........................................
2. ..........................................
3. ..........................................
4. ..........................................
5. ..........................................
6. ..........................................
7. ..........................................
8. ..........................................

6. Ажиглагчдын нэрс

1. ..........................................
2. ..........................................
3. ..........................................
4. ..........................................
5. ..........................................

9. Нэмэлт тэмдэглэл ..................................................
.................................................. 18

.................................................
.................................................
.................................................

Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулсан:
1. Орон нутгийн өмчийн төлөөлөгч .................................................

.................................................
2. Хөтлөгч: .................................................
.................................................
2. Тэмдэглэл хөтлөгч

................................................ /албан тушаал, овог нэр/ ................................................
Хөтлөгч ...................................... дуудлагын худалдааны журмыг танилцуулж, дуудлагын худалдаа эхэлснийг зарлав. Өсгөн нэмэгдүүлэх үнийн доод хязгаарыг..................................
/.......... ................................/ төгрөгөөр, дээд хязгаарыг ..............................
./........................................./ төгрөгөөр тус тус байхаар тохиров.

Дуудлагын худалдаа дараах байдалтай явагдав.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

..............................................................................................................................................
..............................................................................................................................................
Дуудлагын худалдааны эцсийн үнэ ........................ төгрөг ......................мөнгө /үсгээр....................................................................................................................../
Удаахь оролцогчийн эцсийн үнийн санал ........................ төгрөг ......................мөнгө /үсгээр.....................................
.............................................................................................................................................../
Дуудлагын худалдаанд ялагчийн овог нэр .......................................................................
оршин суугаа хаяг, харилцах утас .......................................................................
Удаахь оролцогчийн овог нэр, .......................................................................
оршин суугаа хаяг, харилцах утас .......................................................................
Дуудлагын худалдааны тэмдэглэлтэй танилцсан:
Төрийн өмчийн хорооны төлөөлөгч .......................................................................
Дуудлагын худалдааны хөтлөгч: .......................................................................
Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч: .......................................................................
Дуудлагын худалдаанд оролцогч: .......................................................................

Аймгийн ИТХ –ын Тэргүүлэгчдийн
2015 оны 43 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

## *Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах нийтлэг журам*

### Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай " хуулийн 31 дүгээр зүйлийн 4-р заалтыг үндэслэн Орон нутгийн өмчийг эзэмшиг байгууллагууд дэргэдээ сум байгууллагын дарга, захирлын шийдвэрээр " Өмч хамгаалах байнгын зөвлөлийг /цаашид зөвлөл гэнэ/ байгуулан ажиллана. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга , 3 хүртэл гишүүд бүхий орон тоотой байна.

1.2.Аймгийн орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна

1.3. Зөвлөл нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай " хууль , төрийн өмчийн хорооны тогтоолоор батлагдсан журам , өмч хөрөнгийн харилцааг зохицуулахтай холбогдон гарсан аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол , Засаг даргын захирамж, шийдвэрүүд , энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана .

1.4. Зөвлөл нь дотоодын хяналт хийхэд гол ажлаа чиглүүлэх бөгөөд өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомж, журмын хэрэгжилт тухайн байгууллага дээр хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавина.

### Хоёр: Зөвлөлийн эрх үүрэг

2.1 Зөвлөл нь нь байгууллагынхаа өмч хөрөнгийг зөв зохистой , ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж , өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомжийг суртачлах, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар сум байгууллагаас зохиож байгаа ажил, түүний хэрэгжилт , гаргаж буй шийдвэрт хяналт тавина.

2.2 Сум байгууллагын хагас жилийн болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавьж дүгнэлт өгнө. Шаардлагатай гэж үзвэл хяналтын тооллого хийж болно.

2.3 Байгууллагын эзэмшилд байгаа илүүдэлтэй болон элэгдэл, хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн осол гэмтлийн улмаас болон ашиглалтын шаардлага хангахгүй болон үндсэн болон эргэлтийн хөрөнгийг акталж устгах, зориулалтыг өөрчлөх, үнэ төлбөртэй? тогтоон худалдах асуудалд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 52-р тогтоолоор баталсан энэхүү журмын дагуу санал дүгнэлт гаргана.

2.4 Зөвлөлийн хурлын дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгөнд хөдөлгөөн хийх хүсэлтээ байгууллагын дарга / захирал / сумын ИТХ болон аймгийн өмчийн албанд гаргана.

2.5 Зөвлөл нь эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу акталж устгах хөрөнгөнд хяналт тавьж, үнэ тогтоож худалдах, устгах ажлын хэрхэн гүйцэтгэж энэ тухай акт үйлдэнэ.

2.6 Хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө , хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засварын өртөг, мөн хандив , бэлэг тусламж, төслийн хөрөнгөөр авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ тусгасан байдалд хяналт тавьж Өмчийн албанд мэдээлнэ.

2.7 Эвдэрсэн гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон, тухайн зах зээлийн үнийн жишиг ханшаас хэт өндөр үнээр авсан хэт доогуур үнээр борлуулсан үндсэн ба эргэлтийн хөрөнгийг илрүүлж, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авахыг байгууллагын даргаас шаардах эрхтэй.

2.8 Илүүдэл ажлын байр, бусад хөрөнгийг ОНӨ-ийн албаны зөвшөөрөлтэй түрээслүүлсэн эсэх, түрээсийн орлогыг өөрийн орлогын төлөвлөгөөтэй бол өөрийн дансанд 100 хувь, орлогын төлөвлөгөөгүй нөхцөлд аймгийн ОНӨА-ны 030051009 тоот дансанд төвлөрүүлж түрээсийн байрны ашиглалтанд өмч хамгаалах байгууллагын зөвлөл хяналт тавьж ажиллана.

2.9 Үндсэн хөрөнгийн судалгааг тооллогын маягтын дагуу байгууллагын дарга, нягтлан бодогч нар жилийн эцэст Өмчийн албанд гаргаж өгөх бөгөөд уг мэдээллийн үнэн зөв эсэхэд зөвлөл хяналт тавина.

2.10 Зөвлөлийн аливаа шийдвэр нь байгууллагын дарга /захирал/-ын тушаалаар баталгаажна.

2.11 Зөвлөлийн үйл ажиллагаанд Өмчийн албаны ажилтнууд зөвлөгөө өгч хяналт тавьж ажиллах бөгөөд өмч эзэмшлийн гэрээг дүгнэхдээ зөвлөлийн санал дүгнэлтийг харгалзан үзнэ.

***Гурав: Зөвлөлийн хурал***

1.1. Зөвлөл нь тухайн шаардлагатай үед хурлаа хийж, байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, эзэмшилт ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар дүгнэлт хийж, хийсэн ажлынхаа талаар тайлан гаргаж хамт олон болон өмчийн албанд мэдээлнэ.

1.2.Зөвлөлийн дарга хурлыг товлож, нарийн бичгийн даргаар дамжуулан бусад гишүүдэд зарлана.

1.3.Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд гишүүдийн дийлэнх олонхи оролцсон нөхцөлд хүчин төгөлдөр болно.

1.4.Хурлын тэмдэглэлийг хоёр хувь үйлдэж хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болж гарсан санал дүгнэлтийг /байгууллагын дарга / захирал/-ын тушаалаар баталгаажуулна.

1.5. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй болсон гишүүн саналаа урьдчилан бичгээр өгнө.

1.6. Зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, уилрал бүрийн эцэст гишүүн бүрээр хуралд оролцсон байдал, гаргасан санал, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулна.

1.7. Зөвлөл хийсэн ажил хурлын материалаа баримтжуулсан тусгай ажлын хавтастай байна.

***Дөрөв: Хүлээх хариуцлага.***

4.1 Журамд заасан эрхийг хэтрүүлсэн, үндсэн хөрөнгийг данснаас хасахтай холбогдсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, тухайлбал үнийн дүн, ашиглалтад орсон огноог санаатайгаар буруу тавьсан, журамд заасныг өөр үндэслэлээр данснаас хасах дүгнэлт, санал гаргасан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг өөрөөр захиран зарцуулсан, бусад өмчийн этгээдэд өмч өгч завшуулсан, хувьдаа ашиглан шамшигдуулсан буюу эдгээртэй адилтгах бусад үйлдэл хийсэн гэм буруутай этгээдийг хуулийн байгууллагад шилжүүлнэ.

4.2 Хууль тогтоомж зөрчигдөд хүлээх хариуцлага хүлээлгэхээргүй бол "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 82-р зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

__________________oOo__________________

158

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 13 өдөр Дугаар 44 Нөмгөн

Актлагдсан хөрөнгөд залруулга
хийх тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар тогтоолоор Баянхонгор сумын 7 дугаар Цэцэрлэгийн 14 нэрийн 2423886,01 төгрөгийн хөрөнгийг актлуулах шийдвэр гаргуулсан. Гэтэл актлагдсан хөрөнгийн жагсаалтыг ирүүлэхдээ дахин үнэлсэн балансын үнээр тусгаагүй 8 нэрийн хөрөнгийн үнийг буруу гаргаснаас 702164 төгрөгийн зөрүү үүссэн байна. Иймд өмнөх шийдвэрийн дүн дээр 702164 төгрөгийн үнийн залруулга хийх шаардлагатайг тэмдэглээд "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 3 дах заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам"- ын холбогдох заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар тогтоолоор актлагдсан хөрөнгийн дүн дээр 702164 төгрөгийн үнийн залруулгыг нэмж нийт 3126050 төгрөгийн хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар акталж данснаас хассугай.

2. Актлах хөрөнгийн жагсаалтыг буруу гаргаж, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулан хариуцлагагүй ажилласан Баянхонгор сумын 7 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч Ц.Мөнхтуяа, нягтлан бодогч А.Доржнамжилмаа, нярав Х.Хүрэлбаатар нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

3. Акталсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлт хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА Д.ШИРМЭН

D;2015on/ITHT_Togtool2015

0114489

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
44 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

7 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН АКТАЛСАН ХӨРӨНГӨД ЗАЛРУУЛГА ХИЙСЭН ЖАГСААЛТ

| № | Сумын нэр | Байгууллагын нэр | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ | Элэгдэл | Үлдэгдэл өртөг | Өмнөх санал | Залруулга хийсэн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баянхонгор сум | 7-р Цэцэрлэг | Булангийн буйдан 65000 | 1998.01.01 | 1 | 117000 | 117000 | 117000 | 0 | 65000 | 52000 |
| 2 | Баянхонгор сум | 7-р Цэцэрлэг | Дрож 35000 | 1998.12.25 | 12.25 | 35000 | 428750 | 428750 | 0 | 428750 | 0 |
